

АЛТАЙН УРИАНХАЙН УГСАА ГАРАЛ, ТҮҮХИЙН АСУУДАЛД

Ц. Баатар, Ц. Гантулга

Монголчууд бидний өвөг дээдсийн бичмэл түүхийн хосгүй нандин дурсгал «Монголын нууц товчоо»-нд суут богд Чингис хааны дээд уг Бөртэ-чинуагаас эхлэн язгуурын монгол аймгуудын гарал үүсэл, тэдгээрийн дунд ураг төрлийн байгуулал задарч шинэ шинэ овог үүсэн гарч байсныг дурьдаж Өгөдэй хааны үеийг хүртэлх монголчуудын таван зуугаад жилийн түүхийг хураангуйлан үзүүлжээ. Үүнээс одоогийн Алтайн Урианхай ястны өвөг дээдсийн гарал үүсэл, холбоо хамаарлыг авч үзье.

Урианхайчуудын өвөг дээдэс VШ-ХП зууны үед Хэнтийн нурууны орчим Хэрлэн, Онон, Туул голын саваар төвлөрөн нутаглаж байсан язгуурын монгол аймгуудын нэг Урианхан юм.

Нууц товчоо, Судрын чуулган зэрэг судар цадиг, түүхэн домог аман уламжлалаас үзэхэд Урианхан аймаг Дарлигин монголчуудын өвгөч хүчирхэг овог аймгийн нэг байсан ажгуу. Монголчуудын гарал нүүдлийн тухай Эргүнэ Хунгийн түүхэн домгоор бол, бүх монгол аймгийн угсаа гарал нь Эргүнэ Хунд нүүдэллэн очсон Нукуз Киян хэмээх хоёр овог аймгаас анх үүсч, улмаар өнөржин олон овог аймаг болон салбарласан түүхтэй. Урианхан аймаг ч эндээс үүссэн болохыг Судрын чуулганд тодорхой тэмдэглэсэн байдаг.¹

Чингис хааны дээд уг Бөртэ-чинуа ч дээрх домогт гардаг. Энэ нь Урианхан овог Бөртэ-чинуатай удмын холбоотой болохыг илтгэнэ. Дашрамд тэмдэглэхэд Эргүнэ Хун хэмээх газар усны талаар эрдэм тэд янз бүрийн санал дэвшүүлсэн байдаг. Түүхч Д. Гонгор Нууц товчоо, Судрын чуулган хоёрыг иш үндэс болгон Эргүнэ Хун нь БНМАУ ын Хөвсгөл аймгийн Чандмань-Өндөр сумын нутагт буй Аригийн гол буюу Ариг усны зэргэмжээ нутаг² гэж тогтоосон нь нэлээд үндэслэлтэй дүгнэлт юм. Түүхч Г. Сүхбаатар Монгол овог аймгийн гарал үүсэл, нүүдлийн тухай Рашид-ад-Диний тэмдэглэж үлдээсэн Эргүнэ Хунгийн Дээрх домгийн тасархайг Нууц товчоо, Лу, Алтан товч, Эр дэнийн товч болон бусад сурвалжуудаар нөхөн тодруулж зарим түүхэн домгуудтай харьцуулан задлан шинжилж үзээд энэхүү түүхэн домог эдүгээгээс 2000 гаруй жилийн тэртээх манай өндөр өвөг Хүннү гүрний үед холбогдоно³ гэжээ. Үүнээс үндэслэн өндөр өвгийн үед ч Урианхан овог аймаг энэ л нэрээрээ байжээ гэж үзэж болох байна. Энэ нь Урианхайн угсаа гарал монголчуудын эртний өвөг дээдэстэй шууд холбоотой болохыг гэрчлэх баримт юм.

Чингис хааны өндөр өвөг Бөртэ-чинуа нь харьяат албат иргэдээ дагуулан Онон мөрний эх Бурхан халдун ууланд нүүдэллэн ирж нутаглажээ.⁴ Тэр цагаас хойшхи монголчуудын түүхэнд холбогдох түүхэн үйл явдал бүхэн Бурхан халдун уул, Бурхан халдуны эзэн Уриан хан аймагтай нягт холбоотой болохыг Нууц товчоо бусад судар цадиг гэрчилнэ.

Нууц товчоонд Бурхан халдуны эзэн бурхан босгосон Шинчи баян Урианхан⁵ гэж тэмдэглэсэн байдаг. Үүнийг эрдэмтэн Ш. Гаадамба Шинчи гэсэн нь ойн охин тэнгэр, Бурган гэсэн нь нэгэн зүйл

бургасны нэр (сунжирсаар бурхан болсон) гэж тайлжээ.⁶ Чингэхүл бидний иш татсан дээрх хэллэг нь Бурхан халдуны эзэд бөгөөд бурхан босгосон ойн охин тэнгэр Баян Урианхай гэсэн санаа илтгэсэн болж байна. Нөгөө талаар энэ нь Урианхайчууд эрт дээр цагаас монгол угсаатан овог аймгийн тахилга тайлгыг эрхлэн үйлддэг байсныг нотлон харуулах баримт юм.

Урианхай нар VII зуунаас түүхэнд тэмдэглэгджээ. Урианхай гэдэг нэрийн талаар эрдэмтдийн дунд янз бүрийн санал байдаг. Алтайн урианхайчуудын аман домогт: Урианхан овгийнхон эрт цагаас нум сумаа агсан ан гөрөө авлаж, ур дарх хийж, уул усаа шүтэж ирсэн хэзээнээс хөнгөн шаламгай, эрэлхэг зоригтой дайчин удамтай учир дайн тулаан бүхэнд «уриа» болж уриалан оролцдог эрэлхэг дайчин, ялан дийлэхийн их онгодтой явснаас тийнхүү нэрлэх болсон хэмээнэ.⁷

Түүхч А.Очир Урианхай гэдэг нэрийн эхний «уриа» нь овгийн уриа дуудлагын уриа, «хан» нь эзэн гэсэн санаа⁸ илтгэх бөгөөд нийлээд «уриан эзэн», «онгодын эзэн» гэсэн санаач гэж тайлсныг урианхай ардын аман домогтой харьцуулж үзэхэд нэлээд үндэслэлтэй санал болох нь тодорхой байна,

«Нууц товчоо» зэрэг сурвалж бичгүүдээс үзэхэд Урианхай гэдэг нэрийг хэрэглэхдээ нарийн заагтай, ёс журамтай ханддаг байжээ. Жишээ нь: аймгийг «Урианхан», овгийг «Урианхай», урианхай овогт хүнийг хүйс ялган «Урианхайдай», «Урианхайжин» гэж бичиж хэвшсэн байна.

Урианхан аймаг тарж бутарснаас хойш гол төлөв Урианхай гэдэг байсан бололтой. Энэ бүхнээс үзэхэд Урианхай гэдэг нэр түүхэнд тэмдэглэгдсэн үеэсээ аваад овог ургийн холбогдолтой нэр байсан болохыг илтгэн харуулж байна.

Эргүнэ Хунгийн домгийг үндэслэвэл Урианхан аймаг Тэндээс гарсан олон овог аймгийн хамтаар уван цуван нүүдэллэж Байгаль нуур, Баргуужин төхөмд нутаглаж байгаад ан гөрөө элбэгтэй, ус бэлчээр сайтай нутаг ус сэлгэн нүүдэллэсээр VIII зууны орчим Бурхан халдунд ирж нутаглан энэ нутгийн эзэн болсон түүхтэй билээ.

Ийм алдар түүхтэй язгуурын монгол аймгийг зарим эрдэмтэд түрэг угсаатан аймаг гэж эндэж ташаарсан байдаг. Тэд гол төлөв 2 зүйлийн Урианхай буй гэж үздэг. Чухам яагаад ингэж салган хувааж хоёр зүйлийн Урианхай бий болгосон бэ? гэдэг асуулт зайлшгүй гарч ирж байна. Бидний үзэж байгаагаар, энэ буруу ташаа ойлголтын эх суурийг Рашид-ад-Дин тавьжээ. Тэр судрын чуулганд анх удаа ойн иргэнийг «Ойн урианхай» гэж нэрлээд, хоёр хэсэг болгосон урианхайгаа хооронд нь ялгахын тулд нэлээд зүйл тоочин өгүүлсэн боловч өмнө хойно нь давхцуулж ихээхэн зөрчилтэй болгосон төдийгүй түүнийг баталж чадсангүй. Жишээлбэл: дэд ангийн «ойн урианхан» гэсэн хэсэгтээ, энэ аймаг Чингис хааны үед Удачи гэдэг зүүн гарын Мянганы ноёны харьяа байв. Хожим Удачи Мянган өрхтэйгөө хамт зарлигаар Бурхан халдун нэрт газар Чингис хааны онгоныг сахиж хамгаалах болжээ⁹ гэсэн байхад, дөрөвдүгээр ангийн нэгдүгээр бүлгийн «Монгол урианхай» гэдэг хэсэгтээ, Удачи Бурхан халдунд Чингис хааны онгоныг сахин хамгаалж байсан гэдэг тэмдэглэлээ давтсан байна. Тэгж давтахдаа, тэр Удачи «баруун гарын ноёнтон»¹⁰ гэж хэлсэн байна. Энэ мэт олон зүйлийг хооронд нь хольж хутган итгэл үнэмшилгүй болгосон байна.

Өвөр Монголын түүхч Одон Рашид-ад-Диний «Ойн урианхан», «Монгол Урианхан» гэсэн хоёр зүйлийн Урианхан аймаг бий болгосон

учрыг тал бүрээс нь нягтлан судалж үзээд, Урианхан аймаг угаасаа язгуурын монгол угсаатан бөгөөд тэд ой, талыг дамнан ан гөрөө, мал аж ахуй хослон Байгаль нуур, Баргуужин төхөмд нутаглаж байсан нэг л Урианхан аймаг юм. Урианхай бол ойн иргэний түгээмэл нэр огт биш түрэг угсаатан урианхай гэж байхгүй болохыг Нууц товчоо болон бусад олон сурвалжаар нотолж, Рашид-ад-Диний язгуурын Монгол урианхайг хоёр хувааж ойн иргэнтэй хольж хутган ташаарч хоёр зүйлийн урианхай бий болгосны үнэн учрыг тайлж өнөө хүртэлх түүхчдийн маргааныг нэг мөр болгожээ.¹¹

Хятадын түүхч Кэ Цютао «Со-фан бэй-чэн» гэдэг зохиолынхоо дөрөвдүгээр ботийн 2 дахь талд «Умартаар нутагладаг Урианхан аймаг болбоос угаасаа язгуурын монгол аймаг юм» гэжээ. Ер нь хятад сурвалж, судалгааны бүтээлүүдэд Урианханыг язгуурын монгол аймаг гэж тэмдэглэсэн байдаг.

Хөвсгөл орчмын ой тайгаар нутагладаг овог аймгууд ч өөрсдийгөө урианхай гэж нэрлэдэггүй байсан нь Нууц товчоо бусад сурвалж бичиг, судалгааны бүтээлүүдэд тодорхой өгүүлсэн байдаг билээ.

Тагна Соёноор нутагладаг овог аймгуудад Урианхай нэр хадагдсан нь хожмын хэрэг болно. Түүхч С. Бадамхатан Монголын байлдан эзлэлтийн үед Бурхан халдуны Урианхайчууд энэ нутагт нүүдэллэн ирснээс хойш Тагна, Соёны орчмоор нутагладаг ойн олон овог аймгууд түүнд ижилсэн улмаар өөрсдийгөө ч энэ нэрээр нэрлэх болсон гэж нэлээд үндэслэлтэй дүгнэлт хийсэн байдаг.

Нууц товчоо бусад сурвалж бичиг, судалгааны бүтээлүүдийг үндэслэн, Урианхайн угсаа гарлын асуудлыг товчхон өгүүлэхэд ийм буюу.

Одоо бид Нууц товчоог үндэслэн урианхай бусад монгол овог аймгуудтай хэрхэн холбогдох, Монголын нэгдсэн төр улс байгуулахад ямар үүрэг гүйцэтгэсэн болох хийгээд түүний хойчисын тухай цухас авч үзье.

«Нууц товчоонд тэмдэглэснээр Чингис хааны XI үеийн өвөг Добу мэргэн Баргужин төхөмийн Хорилардай мэргэний охин Алунгуаг гэргий болгосон.¹³ Дашрамд өгүүлэхэд түүхч Ч. Далай сурвалж бичиг, судалгааны зохиолуудыг харьцуулан судалж үзээд, Хорилардай мэргэн Урианхай овогт байсан. Алунгуа бол Урианхайжин бүсгүй гэж тогтоосон байна.¹⁴

Алтайн урианхайн өлгийн дуунд Чингис хааны албат бүүвэй Хорилардай мэргэний зээ бүүвэй¹⁵... гэж дуулдаг нь дээрх дүгнэлтийн нэгэн өвөрмөц сонин баталгаа гэлтэй.

Урианхай овогт Хорилардай мэргэн ядрахын цагт ургаа түшиж Бурхан халдуны эзэн Бурхан Босгосон Шинчи баян урианхайн ивээлд багтсан¹⁶ зэрэг түүхэн үйл явдлууд нь Урианхан овог эрт цагаас Чингис хааны өвөг дээдэстэй ахан дүү ураг төрлийн хэлхээ холбоотой, эв найртай, нэг онгон тахилгатай байсныг нотолж байна. Тэр цагт овог аймгууд хоорондоо ийм хэлхээ холбоогоо гүнээ хүндэтгэн үе удамдаа өвлүүлдэг уламжлалтай байжээ. Тухайлбал: Нууц товчоонд өгүүлснээр Чингис хааны X үеийн өвөг Монголын Боржигин овгийн дээдэс Бодончар Урианхайжин овгийн жирэмсэн бүсгүйг гэргий болгон авчээ.¹⁷ Түүнээс төрсөн хөвгүүнийг харь овгийн хүн гэж Жажирдай нэр өгсөн нь Жамуха сэцэний кадаран овог юм. Энэ бүсгүй Боржигин овгийн Бодончараас нэгэн хөвүүн төрүүлсэн нь Баарин овогтой болжээ. Хорчи ноёны овог тэр билээ. Эл түүхэн баримтаас үзэхэд, Боржигин, Жадаран, Баарин гурван овог Урианхай овогтой цусан төрлийн холбоотой болох нь тодорхой байна. Үүнээс үндэслэн

Баарин овгийн Хорчи ноён, Жадаран овгийн Жамуха сэцэнийг «хээл нэгтгэн, хэвлий ганцтан»¹⁸ гэсэн байхад, Боржигин овгийн Тэмүжин мөнхүү Жамуха сэцэнийг «өнөр нэгтгэн», «элэгний ураг»¹⁹ гэж нэрлэжээ. Эхийн талын «цусан төрлийн» холбоотой байсан учир Тэмүжин, Жамуха хоёр бүр багаасаа айл саахалт байж үерхэж нөхөрлөж явсан байна. Энэ тухай Нууц товчоонд батлан өгүүлсэн буй.²⁰ Энэ бүхэн нь өнөөгийн Монголын олон ястны өвөг дээдэс олон зууны тэртээгээс эхлэн удам төрлийн олон янзын холбоогоор салшгүй холбогдож улмаар МОНГОЛ хэмээх дэлхийд алдаршсан үндэстнийг бий болгосныг харуулж байна. Урианхай аймгийн Жарчиудай өвгөн Боржигин овогтой ургийн холбоо, цусан төрлийн барилдлагатай, ахан дүүсийн ойр дотно харилцаатай айл зэргэлдээ аж төрдөг байсан учир 1162 онд Чингис хааны мэндлэхэд Бурхан халдун уулнаас Ононы Дэлүүн болдогт Есүхэй баатрын очиж хүүд нь булган өлгий бэлэглэсэн байна.²¹

Чингис хааны идэр байхад буюу 1178 онд Жарчиудай өвгөн өөрийн хайртай хөвүүн Зэлмээ дагуулж ирээд «Эмээлээ тохуул» «Үүдээ сөхүүл»²² гэж өгчээ. Тэр цагаас хойш Тэмүжинтэй дотно нөхөрлөж 40 гаруй жилийн турш зовлон жаргалаа хамтатган тулгар төр байгуулахын төлөө нэгэн үзүүрт сэтгэлээр зүтгэсэн гавьяат дээдсийн маань нэг нь Аданхан Урианхай Овгийн Зэлмэ билээ.

1189 онд Зэлмэ, Боорчийн хамт «бүгдийг ахлах» төрийн их сайдын соёрхол хүртэж, өдөр ирэх бүр хуран зузаарч байсан хамаг Монгол улсын дотоод гадаад хэргийг төвхнүүлэн засах нүсэр алба хаших болсон байна. Энэ үед залуу Чингис хааны товлон тогтоосон чиглэл, Зэлмэ, Боорчи хоёрын улс гэрийг захиран засах туршлага нь дараа үеийнхээ авьяаслаг сайд, түшмэдийг төрийн албанд суралцах суурь дэвсгэр болж өгсөн юм.

Хар нохой жил буюу 1202 онд тайчуудтай дайтахад Чингис хааны олсон хүнд шархыг анагаан амийг нь сахиж чадсанаар Зэлмэ баларшгүй гавьяа байгуулсан билээ. Зэлмэ, Чингис хааныг үхлээс хэдэнтээ аварсан ачит хүн, үнэн итгэлт журмын нөхөр нь байлаа.

Тийм ч учраас Чингис хаан Зэлмийг олонтаа дурсан үнэнч шударга үерхэл нөхөрлөлийн ариун дуулал болгон алдаршуулсан байдаг. Жишээ нь:

«Улс төрийн төлөө

Урьд цагаас зүтгэсэн

Урианхайн сайн

Зэлмэ минь²³ гэх буюу

«Сүүдрээс өөр

Нөхөргүй байхад

Сүүдэр минь болж

Сүүлнээс өөр

Ташуургүй байхад

Сүүл минь болж

Сэтгэлий минь сэргээж

Санаагий минь амруулсан

Зүрхний дотно нөхөр²⁴

«Булган өлгийд төрсөн

Буянт нөхөр минь

Хамт төрөөд хань болж өссөн

Хайрт нөхөр минь²⁵ гэх зэргээр эзэн Чингис сайн нөхөртөө үнэн сэтгэлийнхээ үгээ харамгүй хэлж гүн хүндэтгэлээ үзүүлж, ачийг нь олонтаа дурсаж алдар гавьяаг нь мөнхжүүлэн зарлиг буулгаж байс-

ныг Нууц товчооны олон зүйлд тодорхой тэмдэглэн үлдээсэн байна.²⁶

Урианхайн Сүбээдэй Чингис хааны дөрвөн их хөлөг баатрын нэг болж төр улсыг төвхнүүлэхийн төлөө хүчин зүтгэлцэж алдар суугаа дуурсгаж, гүн хүндэтгэл хүлээсэн Чингис хааны цэргийн нэртэй томоохон жанжнуудын нэг нь байжээ. Тэгээд ч Чингис хаан Сүбээдэйг Төгсбаатар Сүбээдэй, өрлөг Сүбээдэй, Чин зоригт Сүбээдэй, Үнэн итгэлт Сүбээдэй²⁷ гэх зэргээр олонтаа алдаршуулан дуулсан байдаг.

Хөх Монгол улсын нэгдсэн төрийн эхэн үед нийгэм-эдийн засгийн зүй ёсны шаардлагаар хөрш орнуудтай зах зээлийн харилцаа тогтоох нь тулгамдсан асуудлын нэг болжээ. Үүнийг дипломат аргаар шийдвэрлэхийг зорьсон боловч хөрш Алтан улс, Сартуул улс үл зөвшөөрч хоорондоо зөвшин Монгол улсад эдийн засгийн хориг арга хэмжээ авч зах зээлийн харилцаа тогтоохоос татгалзсан байна. Үүнээс болж Монгол улс «эдийн засгийн бүслэлтэд» оров. Ийм үед зах зээл эзэмших буюу дахин хуваах эцсийн арга нь дайн байжээ. Тэр дайныг хэр амжилттай явуулахаас Монгол улсын хувь заяа хамаарах болов. Чухам энэ үед урианхайн Сүбээдэй баатар тодорчээ.

Сүбээдэй аданхан урианхайн язгууртан Хабалын дэд хүү болон 1176 онд мэндэлжээ. 14 насандаа Чингис хааны санг хамгаалах албанд тохоогдож 1206 онд Мянганы ноён болов. Хэрлэн голын хөвөөнөөс Чуй мөрөн хүртэл нэхэж мэргэдийн үлдэгдлийг бут цохисноос хойш «Төмөр тэрэгт Сүбээдэй» хэмээн алдаршив.

1219 онд Сартуулыг довтлоход Сүбээдэй Зүчийн дэргэд явж Самаркандын байлдааны дараа тусгай зарлигаар Мухамед-шахыг нэхэмжлэн Европ, Азийн газарзүйн хилийг давсан зэрэг олон дайныг ахалж явсан байна. Сүбээдэй Чингис хааны сүүлийн аяныг элээн Яргай хотноо хар тугаа залаад нөгчсөн эзнийхээ шарилыг хамгаалан эх нутагтаа авч иржээ.

Өгөдэй хаан эзнийн орыг залгамжилсны дараа гүнжээ Сүбээдэйд буулган өгч түүний төрд байгуулсан гавьяаг гэрэлтүүлэв. Тэр үеэс Сүбээдэй Монгол цэргийн ерөнхий захирагч болж, Алтан улсыг дайлах ажлыг толгойлжээ. Алтан улсыг дайлж дуусаад 1235 оноос Бат хааныг дагалдан өрнө зүг хоёр дахь аялалаа хийхдээ Зүүн Европыг туулжээ. Сүбээдэй баатрын оролцсон хийгээд удирдсан энэ бүх аялал дээр өгүүлсэн Монгол гүрний эдийн засгийн хориг саадыг арилгаж, улс төрийн нөлөөг батжуулахад чиглэж байв. Энэ бүхнээс үзэхэд Сүбээдэй Монгол улсын мандан бадрах хувь заяаны төлөө гарамгай гавьяа байгуулсан дээдсийн маань нэг болох нь тодорхой байна.

«Юан улсын судар»-т тэмдэглэснийг үзвэл Сүбээдэйн үр ач гурван үеэрээ Чингис хаан түүний залгамжлагчдад үнэнч шударгаар хүчин зүтгэж явсан байна. Сүбээдэйн дээдэс Онон мөрний сав дагуу нүүдэллэн мал маллаж Чингис хааны IV үеийн өвөг Тумбинай сэцэнтэй дотно нөхөрлөж, Чингис хааны үе болоход хоёр этгээдээрээ нэгдэн таван үеийн найртай явжээ. Сүбээдэй хийгээд Урианхайн эрэлхэг дайчин хөвгүүд, ач нар Чингис хаан түүний залгамжлагчдыг насан өндөр болтлоо даган явж газрыг бартал тойрон байлдаж гайхамшигтай гавьяа байгуулсан тул Чингис хааны алтан урагтанд гавьяат сайдын сурвалжит өрх гэж сайшаагдсан байна.²⁸ Сүбээдэй Гүюг хаан (1246—1248) их орд суух үед нэгэнт нас ахиж 1246 онд Туул голд бүхий хөдөө гэртээ харьсан ажээ. Энэ нь тэр цагт Урианхан аймгийн нутаг ус хаагуур байсныг харуулах бас нэг баримт юм. Түүнээс хойш Сүбээдэй эх орноосоо гарсангүй. 1248 онд 73 насандаа таалал төгссөн байна.²⁹

Тувагийн түүхч Эрдэнэсайнбилэгийн Монгуш Урианхайн Сүбээдэй,

Зэлмийн тухай судалгааны сонирхол татсан чамбай өгүүлэл бичиж нийтлүүлсэн байна.³⁰

Чингис хаан монгол угсаатан улсыг нэгтгэн, улс төрийг байгуулахад мятралгүй зүтгэсэн журмын сайн нөхдөө Мянганы ноёд болгон өргөмжлөхдөө Зэлмийг есдүгээр мянгатын ноён бөгөөд есөн ослоос хэвтрүүлэхээр зарлиг болгож, Сүбээдэй, Зэлмийн дүү Чаурхан баатар нарыг мянганы ноёд, Сүбээдэйн хүү Есөнтэй баатрыг мянган хорчины захирагч болгосон байдаг.³¹

Дээрх үйл явдалтай холбогдуулан нэгэн шинэ баримт өгүүлэхэд Зэлмэ мянганы ноёноор өргөмжлөгдөж их найр хийх үед зохиосон хэмээх түүхтэй «Сундаалингийн ногоо» гэдэг найрын дууг Алтайн Урианхайчууд үеэс үе дамжин өнөө хүртэл дуулсаар байна.³² Олон бадагтай, бадаг бүртээ суут богд эзэн Чингис, ноён Зэлмээгээ магтан дуулсан энэ дууг эзэн Чингисийн үеийн найрын дууны арвин их сангаас бидэнд үлдсэн ховорхон олдох дээж гэлтэй.

Ийнхүү Урианхай аймаг, түүний эрэлхэг хөвгүүд Чингис хаантай дотно нөхөрлөж монгол угсаатан улсыг нэгтгэх төрийг төвхнүүлэхэд оройлон оролцож онцгой гавьяа байгуулж төр улсын түшиг, тулгуур бага нь болж явсан болохыг Нууц товчооны 50 гаруй зүйлд тодорхой тэмдэглэжээ.

Чингис хаан Урианхайг гал голомтоо сахисан отгон хүү Тулуй, ууган хүү Зүч нарын хувь эзэмшилд өгөхийн хамт засаг захиргааны хувьд 4 мянганд хувааж, Урианхайн Зэлмэ, Сүбээдэй Отачи (Удачи) нарыг мянганы ноёд болгосон, тэдний нэг мянган нь Монголын хаадыг онголсон Бурхан халдуны их хоригийг тусгайлан сахиж хамгаалдаг хүндтэй алба хашиж байжээ. Энэ нь жирийн нэг тохиолдлын хэрэг биш Монголын нэгдсэн төр улсын үед их нэр хүндтэй төрийн тулах багана итгэмжлэн түших хүчирхэг аймаг нь Урианхай байсныг нотлох тодорхой баримт юм. Хожим нь Урианхан аймаг Тулуй хааны тавдугаар хүү Аригбөхийн эзэмшилд очсон байна. Гэвч тухайн цаг үеийн ээдрээт нөхцөл байдал зөрчил тэмцлийн дунд Урианхайчууд урьдын хүчирхэг, нэгдмэл байдлаа удаан хадгалж чадсангүй хэд хэдэн хэсэгт хуваагдан задрахад хүрчээ. Энэ нь ХШ зууны сүүлийн П хагасаас Чингис хааны алтан ургийн дотор хаан ширээ эрх мэдлийн төлөө тэмцэл хурцадсан, Монголын эзэнт гүрний улс төрийн байдал ээдрээтэй болж, Хубилай, Аригбөх, Хубилай-Хайду нарын дунд төрийн эрх булаалдаж тэмцэлдсэн хэдэн арван жилийн дайн хямралдааны хөлд Урианхай аймаг ихэд өртөгдөж нэрвэгдсэн зэрэгтэй шууд холбоотой юм. Үүний улмаас нэг хэсэг нь уугуул нутагтаа үлдэж нөгөө хэсэг нь түүхийн янз бүрийн цаг үед Монгол орны баруун зүүн өмнө зүг уран цуван нүүдэллэж тархан суурьших болсноор Урианхайчуудын урьдын сүр хүчин ихэд буурсан байна. Тухайлбал: Чингис хааны дүү Хачиуны хөвгүүн Элжигидэйн хувь эзэмшилд очсон 3 түмэн Урианхайчууд XIV зууны сүүлчээс Хятадын их цагаан хэрмийн хойд бие дагуу нутаглах болсон нь түүхэнд Урианхайн 3 хошуу гэж нэрлэх болжээ. Тэд Нагачу ноён, Доголон тайжийн удирдлагын дор тухайн үеийн түүхэнд тод мөрөө үлдээсэн бөгөөд түүний үйлдвэр хойчис нь эдүгээ БНХАУ-ын ӨМӨЗО-ы Шилийн гол аймгийн Хорчин баруун, зүүн хошуунд нутаглан сууж байна.³³

Уугуул нутагтаа үлдсэн Урианхай нь XVI зууны үес хүртэл халах цахар түмэнтэй нийлж Зүүн Монголын зүүн гурван түмний нэг хүчирхэг түмэн нь байв. Батмөнх даян хааны үед монголчуудын өөр хоорондын хямралдаанаас болж Урианхай түмэн тарж бутарсан түүхтэй. Түүний нэг нь Гэрсэнзийн мэдэлд очжээ. XVI зууны дунд үеэс Гэрсэн-

зийн бага хатан урианхай Отгийн Мэнд өрлөгийн охин Мөнхүйгээс төрсөн отгон хүү Саму-Буймагийн хувь эзэмшил болж халх 7 хошууны эх үүсвэрийг тавилцсан байна. Тиймээс түүхэнд халх-урианхайчууд хэмээн тэмдэглэх болжээ. Халх ястны салшгүй бүрэлдэхүүн хэсэг болсон халх-урианхайн хойчис эдүгээ Дорнод, Хэнтий, Сүхбаатар, Баян хонгор, Архангай, Завхан, Говь-Алтай зэрэг олон аймагт тархан сууж байна.³⁴

Харин Аригбөхийн эзэмшилд очсон Урианхайчууд Байгаль нуурын баруун өмнө биеэр нутаглаж байгаад зарим Монгол овог аймгийн хамт ХШ зууны эцэс XIV зууны эхээр баруун зүг нүүдэллэн явсаар Алтайн нуруу, Эрчис мөрөн, Эмээл гол, Ил тарвагатай, Эрээн хавирга, Бор талын зэргэмжээ газрын өргөн уудам нутагт суурьшин нутаглах болсон³⁵ нь хожмын түүхэнд Алтайн урианхайчууд хэмээгдэх болсон ажгуу. Тийнхүү эртний сурвалжит Урианхан аймгийн нэг хэсэг нь Монгол орны баруун хязгаарт нүүдэллэн очиж, Ойрад Монголын тулгын чулууг тавилцсан түүхтэй. Анхлан Ойрад Монголын бүрэлдэхүүнд Урианхай, буюу Цорос, Хошууд, Торгууд хэмээх гурван гол овог аймаг багтаж Урианхайн Цорос овгийн Махмуд захирч байжээ.

1487 онд Цоросоос Өөлд тасарч гарснаар хожим Өөлд- Урианхай ч гэж нэрлэгдэх нь байв. Мөн түүнчлэн 1502 онд Цоросоос Дөрвөд тасарч аймаг болон салав. Ийнхүү XVI зуунаас Ойрадын холбоонд 3 бус 4 аймаг багтах болсноор дөрвөн Ойрад хэмээгдэх болжээ.³⁶

Улсын нийтийн номын сангийн гар бичмэлийн санд буй Урианхайн уг язгуур, гарал үүслийн товч түүх, шаштирт «Дөрвөн ойрад хэмээгч эдүгээ Урианхай нарын язгуур овог мөн болой» гэж цохож тэмдэглэсэн байдаг.³⁷

Цорос нь эртний сурвалжит Бурхан халдуны эзэн явсан домогт Урианхан аймгийн үр сад, удам хойчис мөн бөгөөд Цоросын ноёд болбоос Чингис хааны шадар Аданхан Урианхайн Жаричудай өвгөний хүү өрлөг Зэлмийн VII үеийн үрийн үртэс, уг шаг нь билээ.³⁸ Тиймээс ч аданхан овог энэ зууныг хүртэл Алтан Урианхайчуудын дотор хадгалагдсаар ирсэн юм. Алтайн Урианхайн нэр сүр Цорос овгийн ноёд Ойрад Монгол, Зүүн гар (Баруун монгол)-ын төр барьж байх хугацаанд буюу Махмудын хүү Тогоон тайш (1418-1438), Эсэн тайш (1418—1455), Хархул хаан (-1634) түүний долдугаар хүү Галдан бошигт (1671—1695) -ын үед ихэд алдаршиж явсан бөлгөө. Энэ үеийн тухай Урианхай ардын уртын дуунд олонтаа өгүүлдэг. Жишээлбэл:

«Дөрвөлжин сайртай Шаргал нь
Дөрвөн туурайдаа тахтай
Дөрвөн ойрадын дундаас
Бид бүгдээрээ жаргалтай» гэх буюу
«Дөрвөн зүгтээ сантай
Дөрвөлжин их Алтай минь
Дөрвөн түмээрээ суухад

Жаргал ихтэй Алтай минь» гэх зэрэг дөрвөн ойрад, зүүн гарын үед холбогдох уртын олон зуун сайхан дууг одоо хүртэл Алтайн урианхайчууд дуулсаар байна.³⁹

VIII зууны дунд үеийг хүртэл Урианхайчууд Бор тал, Ил тарвагатай, Эрээн хавирга, Эмээл гол хавиар нутаглаж байв. Тийнхүү зүүн гарын хаант улсын улс төрийн бодлогын төв дунд Урианхайчууд оршин сууж байсан учир түүхийн эгзэгтэй үед бий болсон элдэв зөрчил бэрхшээл, үйл явдлын өрнөлт бууралт бүхэн Алтайн Урианхайг тойрч өнгөрсөнгүй. Олон жилийн хямралдаан, тэмцэлдээний хөлд багагүй нэр-

вэгдэж нэр нөлөө нь суларсан хэдий ч бие даасан байдлаа алдаагүй юм. Иймээс ч угаас эрэлхэг дайчин удамтай Урианхайчууд Манжийн түрэмгийлэгчдийн эсрэг Монголын тусгаар тогтнолын сүүлчийн голомтыг аврахын төлөө тэмцэлд оройлон оролцож тэмцсээр 1757—1758 онд Манжид эзлэгдсэн нь түүхийн сурвалжид тэмдэглэгджээ. Манж нар ард түмний зэвсэгт бослогыг цус урсган дарж улмаар дахин сэргэж, өндийн босож тэмцэхээс айн болгоомжилж хүйс тэмтрэх, тараан бутраах, хатуу ширүүнээр дарлан мөлжих бодлого явуулсан нь нийт баруун Монголын ард түмнийг, түүний дотор Урианхайчуудын хувьд бүр ч хүнд тусч ихээхэн хэлмэгдэж үлэмж туйлдан доройтсон байна. Энэ тухай Манжийн түүхийн сурвалжид тодорхой тэмдэглэн үлдээсэн байдаг.⁴⁰ Энэ үеэс буюу XVIII зууны сүүлчийн хагасаас Урианхайчууд гол төлөв Алтайн нурууны ар, өвөр биеэр нутаглан суух болжээ.

Ховдын Хэвэ амбан Пуй-И Тэнгэр тэтгэсэн хааны 27 он буюу 1762 онд Манжийн хааны зарлигаар Алтайн Урианхайг 7 хошуу, хоёр гарт хуваан захирах болсон байна. Алтайн Урианхайн долоон хошууны баруун гарт Баруун амбан, Мээрэн гүн, Саруул гүний гэсэн 3 хошуу, Зүүн гарт Зүүн амбан, Сэндэн гүн, Шарда, Махбарьдын гэсэн 4 хошуу тус тус харьяалагдаж хоёр гарын амбан захирагчийн аль нэгэнд сул амбан цол зүүлгэн 7 хошууны хэргийг ерөнхийлөн захируулдаг болгосон байна. 1907 онд Ховдын хязгаараас Алтайн шинэ хязгаар таслахын хамт цаад этгээдэд суусан нь Алтайн Шар сүмд, наад этгээдэд суусан нь Ховдод төвлөн захирагдах болсноор Алтайн Урианхайчууд хоёр хуваагдсан байна.

Манжийн үед Урианхайчууд Алтайн арванхоёр сүвийг сахисан уулын овоо, талын хөшөө болсон урианхай хэмээн нэрлэгдэж хайч халхавчинд зогсож, Ховдоос Тарвагатай хүртэлх 8 суурь өртөөний албыг дагнан залгуулж, дээр нь анчин гөрөөчин удамтай учир ангийн үсний алба давхар оноож байжээ.⁴¹ Эдгээр олон давхар алба Алтайн Урианхайчуудыг ихэд туйлдуулжээ. Энэ байдлыг нүдээр үзсэн Грумм-Гржимайло «Алтайн Урианхай бол баруун хойт монголын хамгийн ядуу ард хэмээвэл зохино»⁴² гэж тэмдэглээд ямар хэцүү амьдралтай аж төрж байсныг тодорхой өгүүлсэн байдаг.

Эрдэмтэн Ж. Цэвээн энэ нутгаар явсан оросын шинжээч Г. Н. Потанин, А. М. Позднеев, Г. Е Грумм-Гржимайло, Г. Ладегин, Сопожников нарын Алтайн Урианхайн талаар бичсэн тэмдэглэлийг өргөн ашиглаж манжийн үеийн урианхайн аж байдал зэрэг түүхэн үйл явдлыг дэлгэрэнгүй өгүүлээд Алтайн Урианхай ястан болвоос монгол угсаатан мөн болох бөгөөтөл нэр нь соён аймагт хэрхэн хадагдсаныг нягтлан судлахын чухлыг онцлон тэмдэглэжээ.⁴³

Ховдын хязгаарыг Манжийн дарлалаас чөлөөлөхөд Урианхайн Лувсангаар удирдуулсан хороо 300 урианхай цэрэг болон бусад урианхайн хороо цэргүүд газар нутгаа сайн мэдэхийн хувьд чухал үүрэг гүйцэтгэн оролцсон байна.⁴⁴

Ховдын хязгаар Манжийн эрхшээлээс ангижрахын хамт Алтайн наад этгээдэд суусан Урианхайчууд Богд хаант Монгол улсынхаа бүрэлдэхүүнд багтан орсон билээ. Богд хаант Монгол улсын үед Алтайн Урианхайчууд Дөрвөдийн Сайн заяат баруун гарын үнэн зоригт хан аймагт харьяалагдах болсны дээр хуучин 7 хошууг Алтайн Урианхайн Итгэмжит, Зүтгэлт, Зоригт, Эетэй, Ёст, Саруул, Дархан засаг, улсад туслагч гүний хошуу гэж тус тус өөрчлөн нэрлэх болжээ.⁴⁵

Алтайн Урианхайн 7 хошууны газар нутгийг засаг захиргааны одоогийн хуваарийг үндэслэвэл: Ховд аймгийн Мөнххайрхан, Дуут,

Баян-Өлгий аймгийн Булган, Дэлүүн, Толбо, Алтанцөгц, Бугат, Сагсай, Буянт, Алтай, Цэнгэл сумын нутаг болой. Мөн түүнчлэн Алтайн цаад биеэр сууж шар сүмд төвлөж байсан Урианхайчууд эдүгээгийн БНХАУ-ын Шинжаан-Уйгурын өөртөө засах орны Алтай аймгийн Алтай хошууны нутагт оршин сууж байна.⁴⁶

Шинжааны багшийн их сургуулиас бэлтгэж, Хөх хотод 1987 онд хэвлүүлсэн «Ойрадын түүхийн тэмдэглэл» номонд Шинжааны түүхч Ту На Шинжааны Урианхайчуудын талаар шинэ соргог материал нийтлүүлжээ. Тэнд бичсэнээр бол 1982 оны хүн амын тооллогоор Алтай хошуунд 4475 монголчууд байгаа ажээ. Тэнд 50 өөлд, 10 цахар өрх, бусад нь бүгд урианхайчууд гэнэ.⁴⁷

Баруун хязгаарыг түйвээж байсан цагаантны болон Османы дээрэмчдээс нутаг орноо чөлөөлөх тэмцэлд Урианхайчууд идэвхтэй оролцож их үүрэг гүйцэтгэжээ. Ардын засгийн эхний жилүүдэд урианхайчууд 7 хошууны зохион байгуулалттаа хэвээр хадгалахын зэрэгцээ 1923 оноос 1 чуулган зохиож Ховдын сайдын жанжны газар захирагдах болсон байна. 1927 онд улсын 3 дугаар их хурлын тогтоолын заалтын дагуу 4 сум хүрэхгүй хошуудыг татан буулгаж нэгтгэх арга хэмжээ авч хэрэгжүүлэх явцад хуучин 7 хошууг цомхотгон Алтай хан уулын Урианхайн баруун, зүүн хошуу гэсэн 2 хошуу болгоод удалгүй дахин нийлүүлж 1929 оноос Алтай хан уулын Урианхайн хошуу хэмээх нэг хошуу байгуулжээ. 1931 онд МАХН-ын 1, улсын XVI бага хурлын шийдвэрийн үндсэн дээр Зөвлөлтийн мэргэжилтний оролцоотойгоор боловсруулан хэрэгжүүлсэн засаг захиргааны шинэ зохион байгуулалт ёсоор Чандмань уулын аймгийг хоёр хувааж шинэ аймаг байгуулахад Ховд аймгийн бүрэлдэхүүнд оржээ. 1940 онд Ховд, Увс аймгаас газар нутаг тасалж Баян-Өлгий аймаг шинээр байгуулснаас хойш Урианхайчууд Ховд, Баян-Өлгий 2 аймагт хуваагдан харьяалагдах болсон билээ.

Дашрамд тэмдэглэхэд, сүүлийн үед хэвлэлд казах, урианхайн ард түмний хүсэлтээр Баян-Өлгий аймаг байгуулах шийдвэр гарсан гэж буруу ташаа бичих болов. Түүх сөхөж үзвэл уугуул нутгийн урианхайчууд аймаг байгуулах хүсэлт ч гаргаагүй, тэдний саналыг ч асуугаагүй, аймаг байгуулах комисст ч оролцуулаагүй болох нь тодорхой байна.

Өнөөдөр Алтайн Урианхайчууд Баян-Өлгий аймгийн Алтай, Буянт, Сагсай, Бугат, Алтанцөгц, Булган, Ногооннуур сум, Ховд аймгийн Дуут, Мөнххайрхан, Төв аймгийн Борнуур, Хэнтий аймгийн Баянхутаг, Чандгана, Өндөрхаан, Сэлэнгэ аймгийн Орхон туул, Цагаантолгой, Ерөө, Баруун хараа, Зүүн хараа, Зүүнбүрэн, Улаанбаатар, Дархан, Эрдэнэт, Өлгий, Ховд, Сүхбаатар, Чойбалсан, Налайх, Шарын гол зэрэг олон аймаг, сум, САА, хотуудад тархан нутаглаж буй. 1989 оны хүн амын тооллогын бүрэн бус мэдээгээр манай оронд 21325 Урианхай ястан аж төрж байгаа ажээ. Алтайн Урианхайд эрхэд (ирхэд), эрхтанд, бүргэд, цагаан туг, оорцог, аданхан, цорс, онход, дөнхөл мундас, дүнхэр, бургууд (баргууд), жавраа, мянгад, нүцгэд, шаазгай, өөлөг, хонголог, харцага, түмт, авга (авга нар), хуурчид (хар, шар), бөөрс боосгон зэрэг олон овог яс (элкэн) байдаг.⁴⁸

Алтайн Урианхайн овгийн бүрэлдэхүүний байдлаас ажиглахад түүний дотор Халх, Ойрад, Буриад зэрэг монгол угсаатны дунд түгээмэл тархсан овог олонтаа тааралдаж байгаа нь тэд язгуурын хүчирхэг өвгөч монгол аймгийн удам хойчис мөн болохын нэгэн баталгаа буюу. Үүнтэй холбогдуулан дурдахад түүхч Х.Пэрлээ, Хэнтий аймгийн Бат-

ширээт сумын нутагт буй Рашаан хадны зурагт дүрслэгдэн үлдсэн мянгаад жилийн тэртээх малын им, тамгын олон дүрс одоо хаана байгаа, ямар ястны тамга болохыг эрэн сурвалжилж нягтлан тодруулж харьцуулан судалсан нь энд ихээхэн сонирхолтой юм. Ер нь малын им, тамга бол овог угсаатны түүхэн уламжлалыг илүү бат хадгалдаг, овог аймгуудын угсаа гарвал, түүхэн холбогдлыг судлахад чухал хэрэглэгдэхүүн болдог билээ. Тэгвэл Рашаан хаданд зурж үлдээсэн зарим им тамгууд Алтайн Урианхайчуудын дунд өнөө хүртэл хэрэглэсээр байгаа малын олон им, тамгатай яв цав тохирч байна. Түүгээр ч барахгүй Халхын Сэцэн хан, Түшээт хан, Сайн ноён хан, Засагт хан, Их шавийн нутаг, хошуудын Урианхай овгийнхон хэрэглэж байсан малын им тамга Алтайн урианхайн одоогийн хэрэглэж байгаа төрөл бүрийн нуман болон гал, чандмана тамга, онь, ганзага, ухам, цуулбар зэрэг им тамгатай тохирч байгаа нь судалгаагаар нотлогдсон байна.⁴⁹ Энэ нь Алтайн Урианхай бол удам гарал уг язгуурын хувьд эртний монголын өвгөч овог болохыг давхар гэрчилж байна.

Энэ бүхнээс үзвэл Алтайн Урианхайчууд нь «Монголын нууц товчоо» зэрэг сурвалж бичигт тодорхой тэмдэглэгдсэн, Бурхан Халдуны эзэн явсан, Монголын нэгдсэн улсын төрийн түшиг тулгуур багана нь байсан түүхэнд тод мөрөө үлдээсэн эртний хүчирхэг язгуурын монголын өнгөч овог аймаг болох Урианхан аймгийн орыг дарж, нэрийг нь өргөж яваа түүний үрийн үртэс уг шаг болохыг нотлон харуулж байна.

Алтайн Урианхайчууд хэл аялгууны хувьд монгол хэлний ойрад аялгуугаар ярилцдаг, тод болон Монгол бичиг үсэг хэрэглэж ирсэн, бөө мөргөлийн эртний уламжлалтай. Түүнчлэн Шарын шашны сургаал ном өргөн дэлгэрсэн (10 гаруй сум дугантай байжээ), өөрийн гэсэн өвөрмөц өнгө төрх бүхий оюуны болон эдийн соёлын арвин баялаг өв уламжлалтай ястан юм. Нэн ялангуяа хэл, соёл, урлаг, ёс заншлын хувьд дундад эртний монгол төрхийг илүү их хадгалан уламжилж үлдсэнээрээ ихээхэн онцлогтой, үнэ цэнэтэй гэж хэлж болно. Энэ нь үндэсний хөгжмийн зэмсэгүүд, хувцас хунар, үлгэр туульс, найр наадам, дуу хуур, биелэгээ зэргээс тодорхой харагддаг. Тухайлбал, өнөө үеийн хэнд олон алдарт туульчид туулиа хайлж үлдээсэн, үндэснийхээ сурын харвааг анх байсан тэр л төрхөөр нь өнөөг хүртэл үеэс үе дамжин өвлүүлэн наадсаар яваа ястан бол Алтайн Урианхайчууд билээ.

Энэ ялдамд өгүүлэхэд манай улсад Алтайн Урианхайн талаар хийсэн зөв судалгаа нэгдсэн ойлголт өнөө хэр хараахан байхгүй байна. Зарим судлаачид урианхайг түүх угсаатны зүйн талаас нь нягтлан судалж үзэлгүй, хөнгөн гоомой хандаж түрэг угсаатантай холбосон нь үзэгдэнэ. Манай зарим түүхчид энэ байдалд шүүмжлэлтэй хандаж нягтлан судлахын оронд дээрх буруу ташаа дүгнэлтийг иш үндэс болгосон хэвээр байна. Тухайлбал, манай нэртэй угсаатны зүйч С.Бадамхатан нэгэн өгүүлэлдээ Алтайн урианхайчууд ойр орчмынхоо түрэг угсаатны бүлгүүдтэй ижилсэх явц үргэлжилж байна⁵⁰ гэсэн үнэмшилгүй дүгнэлт хийсэн нь гайхалтай. Гэтэл түүхийн бодит үнэн тэс өөр бөгөөд Алтайн Урианхайчууд түрэг угсаатанд уусан ижилсээгүйгээр үл барам удам угсаагаа эрхэмлэн сахиж, өвөг дээдсээс уламжилсан өвөрмөц зан заншил, түүх соёлоо нандигнан хамгаалж ирсэн, одоо ч хадгалсаар байгаа монгол туургатны салшгүй нэгэн хэсэг болохыг дээр өгүүлсэн түүх угсаатны зүйн талаархи цөөн баримт баттай нотолж байна.

¹ Рашид-ад-Дин. Сборник летописей, т. 1, КП-1, М., 1952, стр. 153—154

² Д. Гонгор, Халх товчоон, 1 боть, УБ., 1970, 68 дахь тал

- ³ Г. Сүхбаатар, Монголчуудын эртний өвөг. 1980. 184—186-р талд
- ⁴ Монголын нууц товчоо . 1
- ⁵ Мөн тэнд . 9
- ⁶ Ш. Гаадамба. Нууц товчооны нууцаас УБ., 1976
- ⁷ Цаст уулын цуурай. Дуутын 30 жил. ред. Ц. Жарантай болон ардын аман домгоос тэмдэглэж авав.
- ⁸ Этнографийн судлал. УБ., 1985. 12—21-р тал
- ⁹ Рашид-ад-Дин. Сборник летописей. том. 1, кп 1, М., 1952 стр. 123—124
- ¹⁰ Мөн тэнд 156— 160 дахь талд дэлгэрэнгүй үзнэ үү.
- ¹¹ Одон, Урианхан аймгийн улирсан түүх (Өвөр Монголын нийгмийн шинжлэх ухаан) 1985, No 5, 35—51 дэх тал
- ¹² С. Бадамхатан. Хөвсгөлийн дархад ястан, УБ., 1965, 23-р тал
- ¹³ Монголын нууц товчоо. No 8
- ¹⁴ Чулууны Далай Монголия в XII—XIX веках. М., 1983, стр 54 — 55
- ¹⁵ Өлгийн дууг одоогийн Баян-Өлгий аймгийн Алтай сумын харьяат 74 настай нэртэй сийлбэрч уран Самдан хэмээн нутаг усандаа алдаршсан Төмөрийн Самдангаас тэмдэглэж авав.
- ¹⁶ Монголын нууц товчоо . 9
- ¹⁷ Мөн тэнд . 40
- ¹⁸ Мөн тэнд . 121
- ¹⁹ Мөн тэнд . 105
- ²⁰ Мөн тэнд . 116
- ²¹ Мөн тэнд . 97
- ²² Мөн тэнд . 97
- ²³ Мөн тэнд . 149
- ²⁴ Мөн тэнд . 125
- ²⁵ Мөн тэнд . 141
- ²⁶ Мөн тэнд . 145
- ²⁷ Мөн тэнд . 199
- ²⁸ Юан улсын судар - Урианханы намтар
- ²⁹ Юан улсын судар. Сүбээдэн намтар, 121 дугаар дэвтэр
- ³⁰ Тиванын аныяктары, 1989, No 88
- ³¹ Монголын нууц товчоо . 202
- ³² Баян-Өлгий аймгийн Буянт сумын харьяат дууч, ерөөлч улсын мэргэн харваач 64 настай Пүрэвийн Ишээхүүгээс тэмдэглэж авав.
- ³³ Одон, Урианхан аймгийн улирсан түүх (Өвөр Монголын нийгмийн шинжлэх ухаан 1985. № 5, 45-р тал)
- ³⁴ БНМАУ-ын угсаатны зүй 1 боть, УБ., 1987, 31-47 дахь тал
- ³⁵ Ойрад түүхийн сурвалж бичиг, Хөх хот, 1985, 11-р тал
- ³⁶ Н. Бичурин, Записки о монголий Спб. 1928, стр. 129
- ³⁷ Урианхайн уг язгуур гарал үүслийн товч УННС, гар бичмэл Данс No 134648
- ³⁸ «Хан тэнгэр» сэтгүүл, Үрэмч, 1983 No 2, 19-р тал
- ³⁹ Урианхай ардын уртын дуу. УБ., 1982
- ⁴⁰ Цин-Ши-Чао-гийн харь омгийн тухай бүлэг 14519 дахь тал (хятад)
- ⁴¹ Д. Гонгор. Ховдын хураангуй түүх, УБ., 1964, 49—50-р тал
- ⁴² Грумм-Гржимайло. Западная Монголия и урянхайский край. т. Ш. Л. 1926, стр. 170
- ⁴³ ж. Цэвээн. Дархад, Хөвсгөл нуурын урианхай, дөрвөд, хотон, баяд, өөлд, мянгад, захчин... нарын гарал үндэс байдлын өгүүлэл УБ., 1934, 119-127 дахь тал
- ⁴⁴ ч. Дамчаа, Буянтынхан 40 жилд, Өлгий 1982, 20-21-р тал
- ⁴⁵ Монголын өрнөт нутгийн хүн амын аж төрөх ёсны хөгжил. УБ., 1989, 233—234 дахь тал
- ⁴⁶ Урианхайн түүх судлаач Ядамын Нэхийтийн цуглуулсан материалаас
- ⁴⁷ Вэй-Ла-тэ Ши лүн-Вэнь жи» (Ойрадын түүхийн тэмдэглэл) Хөх хот, 1987, 252 дахь тал, хятадаар
- ⁴⁸ Алтайн урианхайн овог яс (элсэн) -ны судалгаа хийхэд Алтай сумын өндөр настан Төмөрийн Самдан, Сагсай сумыг өндөр настан Жинлэвийн Цэндээ. Бугат сумын өндөр настан Нэхийтийн Баасан, Сагсай сумын ард Дампилын Жимбээ,

Буянт сумын ард Дампилийн Тогтох, Сагсай сумын өндөр настан Хожоогийн Өнөр, мөн сумын ард Дармаагийн Дэлгэр, Алтанцэгц сумын харьяат хорхойн Бүрэн, Толбо сумын харьяат Будын Цэрэн, Цэрэнгийн Ядамжав, Булган сумын харьяат Б. Дашням, Алтанцөгц сумын харьяат Бөхийн Бөмбөг, Б. Чимэдцэеэ, М, Чимэдцэеэ, Б. Мягмарсүрэн, Буянт сумын харьяат Банзарын Дамчаа, Бугат сумын харьяат Шалмаагийн Елк нарын зэрэг удам угсаагаа сайн мэддэг хүмүүс оролцов. Энэхүү судалгааны ажлыг 1982—1988 онд хийсэн болно.

⁴⁹ Х.Пэрлээ. Монгол түмний гарлыг тамгаар хайж судлах нь УБ. 1976, 103-109 144, 166, 208—231, 256—257-р талд үзнэ үү.

⁵⁰ Этнографийн судлал. УБ., 1982, 13-р тал